



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/248

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" аяныг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Алтангэрэл (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Д.Чинзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Пүрэвдулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)

Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)

А.Оюун-Эрдэнэ (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч)

Д.Баттайван (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Ц.Бадамгэрэл (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Н.Гэрэлтуяа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний

газрын хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагч)
Д.Батмагнай (Байгаль орчны газрын дарга)
Б.Батсанчир (Мэргэжлийн боловсролын
сургуулийн захирал)
Л.Билэгжаргал (Аймгийн барилгачдын холбооны
тэргүүн)
Ж.Мөнхцэцэг (Аймгийн барилгачдын холбооны
нарийн бичгийн дарга)
Нарийн бичгийн дарга: Ж.Мянганбаяр (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Аяныг зохион байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга (М.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3. Аяныг чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулан, нэгтгэсэн тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэхийг ажлын хэсэг (М.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ